

А.И.МИКОЯНЫ ХЯТАДАД ХИЙСЭН НУУЦ АЙЛЧЛАЛ /1949 оны 1 ба 2-р сар

ЗХУКН-ын Төв Хорооны Улс төрийн Товчооны гишүүн А.И.Микоян 1949 оны эхээр Хятадад нууц айлчлал хийжээ. Энэ айлчлалын үеэр Мао Цзэдун болон ХКН-ын Төв Хорооны Улс төрийн Товчооны Зарим гишүүнтэй хийсэн хэлэлцээний үндсэн агуулгыг Микоян 1960 онд бичсэн Тэмдэглэл бичигтээ илэрхийлэн гаргажээ.

Энэхүү Тэмдэглэл бичигт Москва ба ХКН-ын Төв Хорооны хооронд, Сталин ба Мао Цзедуны хооронд 1947-1949 онд явагдаж байсан харилцааны, урьд ил болоогүй байсан нэлээд материалыг иш татан дурдсан байна. Энэхүү ишлэлээс үзвэл Микоян Тэмдэглэл бичгээ бэлтгэх үед эдгээр материал өөрт нь байсан байна. гэж ойлгогдож байна. Тэгэхдээ энэхүү Тэмдэглэл бичиг нь түүнд хавсаргасан цахилгаан утсууд, ХКН-ын удирдагчидтай явуулсан ярианы тэмдэглэл зэргээс бүрдсэн нэлээд өргөн мэдээллийн нэг хэсгийг л тусгаж байгаа ажээ.

1960 - иад оны үед ХКН-аас бусад орны коммунист намуудтай санал зөрөлдөөнтэй болж энэ зөрөлдөөний асуудлыг хэлэлцэн ярилцах болсонтой холбогдуулж Микоян 1949 оны 1-ба 2-р сард Хятадад айлчлах үедээ Москва руу илгээж байсан мэдээнүүд болон тэдгээрийн хариуд ЗХУКН-ын Төв Хорооноос түүнд ирүүлж байсан чиглэл Заалтуудын бүрэн эхийг Намын Төв Хорооны тэргүүлэгч ба орлогч тэргүүлэгч гишүүдэд танилцуулах зорилгоор тэдгээр баримт бичгүүдийг өөрийн бичсэн Тэмдэглэл бичгийн хамтаар 1960 оны 9-р сарын 22-т тараасан байжээ.

Эдгээр баримт бичгүүд нь эдүгээ ОХУ-ын ерөнхийлөгчийн архивт хадгалагдаж байгаа ажээ. Түүхийн ухааны дэд доктор А.Ледовский архивын материалтай танилцаж тэдгээрээс сэтгүүлийн нийтлэлийн хувилбар бэлтгэж " Алс дорнодын асуудал" /1995.№2,3/ сэтгүүлд хэвлүүлсэн байна. Энэ хувилбарт Микояны бичсэн тэмдэглэл бичгийг бүрэн эхээр нь авч оруулан хавсаргасан бөгөөд он цагийн хувьд 1949 оны 1 ба 2-р сарын баримт бичгүүдээс сэдэвлэн бүлэглэж нийтэлсэн байна

Түүхийн эдгээр баримт бичигүүдийг судлан хэвлүүлсэн А.Ледовский товч тайлбар үг бичиж, түүндээ энэхүү нийтлэлийн ач холбогдол, уг айлчлалыг зохион байгуулах болсон шалтгаан зэргийг товч гаргажээ.

Дэлхийн II дайны дараах зөвлөлт-хятадын харилцааны асуудлыг гэрэлтүүлэн үзүүлэх талаар хэд хэдэн хандлага болон баримтлал үзэгдэж байсныг Ледовский харуулсан. Тухайлбал: - Хятад дахь иргэний дайнд Гоминдан ялагдаж, Засгийн эрхэнд коммунист Засгийн газар 1949 оны 10-р сард гарсны дараа " Хятадыг хэн алдав" гэсэн асуудлыг тойрон АНУ-д улс төрийн тэмцэл хурцдаад Гоминданы, түүний хамт АНУ-ын бодлого ялагдсаны гол буруутан нь ЗХУ хэмээн үзэж ЗСБНХУ-ын үйл ажиллагаа, ХКН-д үзүүлсэн Зөвлөлтийн тусламж дэмжлэг иргэний дайн ХКН-д ашигтайгаар төгсөхөд шийдвэрлэх хүчин зүйл байсан гэсэн сурталчилгааны нэг хандлага; Хожим 60-иад оны үед Мао Цзэдун болон түүний талынхан дээр дурьдсны эсрэг чиглэлийн сурталчилгаа өрнүүлж, Японы эсрэг дайнд ЗСБНХУ Гоминданд туслаж, ХКН-д туслаагүй, 1945 оноос хойш Сталин ХКН-ын дотоод хэрэгт оролцож, "Хятадын хувьсгалд саад учруулж байсан" гэсэн сурталчилгааны нөгөө хандлага үзүүлж байв. Сүүлийн жилүүдэд дурьдсан хандлагуудын зарим сэдэв оросын зохиогчдын нийтлэлүүдэд тааралдах болсон ажээ. Гэвч ЗХУКН ба ХКН, Сталин ба Мао Цзэдуний хоорондын харилцааг үнэлэх талаарх эдгээр хандлагууд нь ихэнхдээ тэргүүн зэргийн чухал баримт бичгийн эх

сурвалжуудад тулгуурлаагүй, бясалгал, санаа бодлоос ургуулан гаргасан шинжтэй юм. Иймээс Москвагийн Хятадын бодлогын энэхүү эзэгтэй үеийн үйл явдлыг зөв харуулах, тэр бодлого 40-өөд оны эцэс, 50-иад оны эхний Хятадын үйл явдалд үзүүлсэн нөлөөг бодитой үнэлэх архивын материалууд үлэмж ач холбогдолтой юм. Тиймээс Микояны Хятадад хийсэн нууц айлчлалд холбогдсон баримт бичгүүд, Мао болон ХКН-ын бусад удирдагчидтай хийсэн ярианы тэмдэглэлүүд, Микоян Москвагийн хоорондын мөн түүнчлэн Сталин Мао Цзэдуний хоорондын шифрийн харилцаа зэрэг нь түүхчид, судлаачид, ер нь түүх сонирхогчдын сонирхлыг зүй ёсоор татах юм.

А.И.Микоян ЗХУКН-ын Төв Хорооны хариуцлагатай хоёр ажилтны хамт 1949 оны 1-р сарын сүүлчээр Порт-Артураар дамжин ХКН-ын байрлаж байсан Умард хятадын Шицзячжуан хотын ойролцоох Сибайпо сууринд 1-р сарын 30 нд хүрэлцэн ирж 2-р сарын 8 хүртэл байжээ.

Баримт бичигт дурдсанаар Микояны энэ айлчлал нь 1947 оноос Хятадын талын санаачлагаар төлөвлөгдөж, тэгээд тухайн үеийн бодит шалтгааны улмаас хойшлогдсоор байсан Мао Цзэдунгийн ЗХУ-д хийх айлчлалын оронд хэрэгжүүлсэн арга хэмжээ юм байна. Микоян тэмдэглэлдээ Мао Цзэдун болон ХКН-ын бусад гишүүдтэй хэлэлцсэн асуудлыг долоон сэдэвт бүлэглэн хувааж бичжээ. Эдгээр нь 1. Хятадын аж үйлдвэрийн төв хотууд / Нанжин, Шанхай/-ыг эзлэн авах тухай. 2. ХКН-ын бүрэлдүүн дэх пролетарийн давхрааны тухай. 3. Хятадын хувьсгалт Засгийн газрыг байгуулах тухай. 4. Порт-Артурын тухай. 5. Синьцзяны тухай. 6. Монголын тухай. 7. Хувьсгалт Засгийн газрыг бусад орноор хүлээн зөвшөөрүүлэх тухай асуудлууд байв.

Эдгээр хэлэлцсэн асуудлын дотроос хоёрт нь Монголын асуудлыг хөндсөн учраас Монголын уншигчдын сонирхлыг татаж байгаа юм. Микоян 1949 онд Хятадад айлчлахад Мао Цзэдун түүнтэй Монголын асуудлыг хөндөж ярилцсан гэдэг нь нийтэд мэдэгдэж байсан боловч ямар томъёололоор, ямар үндэслэлтэйгээр яригдсан нь ил болоогүй байлаа. Микоянтай хамт явсан И.В.Ковалевын ярилцлага 1990 онд "Алс дорнодын асуудал" /№6/ сэтгүүлд нийтлэгдсэн билээ. Тэнд "Гоминданы намын хувьсгалт жигүүрийн удирдагч эмэгтэй" гэгчийг ишлэн "БНМАУ-ыг Хятадын бүрэлдхүүнд" оруулах тухай асуудлыг Мао Цзэдун Микоянд тавьсан, тэгэхэд Микоян "иймэрхүү асуудлыг ярилцах үүрэг аваагүй" гэж хариулсан байсан санагдаж байна гэж дурдсан байдаг. Тэгвэл энэ асуудал Микояны тэмдэглэл бичиг нийтлэгдсэний ачаар тодорхой болж байна.

ЗХУ-ын удирдлага, Тухайлбал Сталин 1940 өөд оны сүүлчээр БНМАУ-ын тусгаар тогтнол, хөгжил дэвшлийн асуудлаар ямар байр суурь баримталж байсан нь Микояны тэмдэглэл бичгээс тод харагдаж байгаа тул тэр эх сурвалж болсон баримт бичгээс "Ү. Синьцзяны тухай", "I. Монголын тухай" гэсэн хоёр зүйлийг сугалан авч орчуулан монгол уншигчдад зориулан "Зүүн хойт Ази судлал" сэтгүүлийн баримт бичгийн буландаа нийтэлж байна.

Хятад явсан тухай ЗХУКН-ын Төв Хорооны тэргүүлэгчдэд бичсэн А.И.Микояны тэмдэглэл бичиг*

"V. Синьцзяны тухай. Энэ асуудал мөн сонирхол татав. Синьцзян дэх манай бодол саналын талаар Мао Цзэдунд хардлага сэрдлэг байсан байна. Тэр яриандаа Синьцзяны Илийн тойрогт Урумчийн Засгийн газарт үл захирагдах тусгаар тогтнолын хөдөлгөөн байгаа тухай, тэнд коммунист нам байгаа тухай дурьдсан юм. Тэр хүүрнэн ярихдаа 1945 онд Чунцинд Бай Чунситэй³¹ уулзсан, тэгэхэд тэр Илийн тойрог дэх орон нутгийн босогчид зөвлөлт хийцийн их буу, танк, нисэх онгоцтой юм гэж хэлж байсан гэв.

Би түүнд ил тод мэдэгдэхдээ, бид Синьцзяны үндэстэн ястангуудын

тусгаар тогтнолын хөдөлгөөний төлөө байдаггүй, тэгэх тусамдаа Синьцзяны газар нутагт ямар нэгэн санаархал байхгүй. Синьцзян бол Хятадын бүрэлдэхүүнд ордог, орох ёстой гэж үздэг юм гэв.

Мао Цзэдун Синьцзяныг дайруулан Хятад, ЗСБНХУ-ын хооронд төмөр зам тавих тухай санал дэвшүүлсэн. Жэнь Биши⁵ өөр нэг хувилбар болгон ийм замыг Монголыг дайруулан тавих санал гаргасан. Энэ саналыг хожим Москвад ярилцахад Сталин ийм замыг Монголоор дайруулан тавих, учир нь зайны хувьд ойр татуу, барьж босгоход хямд болно, харин хоёр дахь ээлжинд Синьцзяныг дайрсан замыг тавих нь зүйтэй гэсэн байна.

ҮІ. Монголын тухай. Гадаад³² ба Дотоод³³ Монголыг нэгтгэхэд бид хэрхэн ханддаг вэ гэдгийг Мао Цзэдун өөрөө санаачилан асуув.

Бид ийм нэгдлийг дэмжихгүй бөгөөд учир нь Хятадын газар нутгийн нэлээд хэсгийг алдахад энэ нь хүргэнэ гэж хариулав. Мао Цзэдун хэлэхдээ Гадаад ба дотоод Монгол нь нэгдэн Бүгд Найрамдах Хятад улсын бүрэлдэхүүнд орж болно гэж үзэж байна гэв. Үүнд би хариулахдаа энэ бол бололцоогүй, учир нь БНМАУ аль түрүүн тусгаар тогтнолоо олсон. Японыг ялсны дараа Хятадын Засгийн газар Гадаад Монголын тусгаар тогтнолыг зөвшөөрсөн. БНМАУ өөрийн армитай, өөрийн соёлтой, соёл болон аж ахуйн хөгжлийнхөө замаар хурдан урагшилж, тусгаар тогтнолын амт шимтийг хэдийнээ танин мэдэх болсон тул тусгаар тогтнолоосоо хэзээ нэгэн цагт сайн дураар татгалзах болов уу даа. Хэрэв БНМАУ нь Дотоод Монголтой хэзээ нэгэн цагт нэгдвэл түүний үр дүнд нэгдсэн тусгаар тогтносон Монгол Улс зайлшгүй үүсэх болно гэж мэдэгдэв. Ярианы үед байлцсан Жэнь Биши энэ үед үг дуугарч дотоод Монгол гурван сая хүн амтай бол Гадаад Монгол нэг сая хүн амтай шүү дээ гэсэн юм. Миний энэхүү мэдээлэлтэй холбогдуулан Мао Цзэдунд танилцуулах зорилгоор Сталинаас надад цахилгаан утас ирүүлсэн. Тэнд:

“Гадаад Монголын удирдагчид нэгдсэн Монгол Улсын тусгаар тогтнолын далбаан дор Гадаад Монголтой Хятадын бүх монгол районыг нэгтгэхийн төлөө байгаа билээ. Зөвлөлт Засгийн газар энэхүү төлөвлөгөөний эсрэг саналтай байна. Учир нь энэ төлөвлөгөөгөө хэдийгээр Зөвлөлт Холбоот Улсын ашиг сонирхолд занилхийлэхгүй ч Хятадаас хэд хэдэн районыг нь таслан авна гэсэн хэрэг шүү дээ. Гадаад Монгол нь Хятад улсын бүрэлдэхүүнд багтах автономийн төлөө, тэгэхдээ бүх монгол районыг автономит нэгжид нэгтгэх ч гэлээ гэсэн өөрийн тусгаар тогтнолоос татгалзана гэж бид бодохгүй байна. Энэ хэрэгт шийдвэрлэх үгийг Гадаад Монгол өөрөө хэлнэ гэдэг нь ойлгомжтой” гэж заан дурдсан юм.

Мао Цзэдун энэхүү цахилгаан утастай танилцаад хэлэхдээ түүнийг өөрийн анхааралд авна, бас “тэд нь аугаа их Хятадын шовинист шугамыг хамгаалахгүй бөгөөд Монголыг нэгтгэх асуудлыг тавихгүй биз” гэжээ.

Зүүлт

А.И.Микояны энэхүү Тэмдэглэл бичгээс Синьцзяны ба Монголын тухай V, VI зүйлийг сугалан авч нийтлэж байна. “Проблемы Дальнего Востока”, 1995. №2, 106-107 тал

31. Бай Чунси (1893-1966) тэр үеийн Гоминданы нэрт зүтгэлтэн

5. Жэнь Биши (1904-1950) тэр үед ХКН-ын ТХ-ны Улс төрийн товчоо ба нарийн бичгийн дарга нарын газрын гишүүн

32. БНМАУ-ыг хэлж байна.

33. Тэр үед Хойт ба Зүүн хойт Хятадын хэд хэдэн мужийн газар нутаг дэх Монголчуудын аж төрж байсан районууд

Хэвлэлд бэлтгэсэн Академич Б.Балдоо